


## ДОТООДЫН САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛ, ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

### ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛ


Зах зээлийн үнэлгээ, индекс

Энэ сард зах зээлийн үнэлгээ 1.32 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 241.4 тэрбум төг буюу 15.5 хувиар буурлаа. MSE all индекс 940 бөгөөд өмнөх сараас 2.3 хувиар буурсан байна.



Компаниудын зах зээлийн үнэлгээнд эзлэх хувь

Энэ сард нийт 208 компаниас топ 5-д АПУ 266.7 тэрбум төгрөг, Таван Толгой 184.3 тэрбум төгрөг, Говь 66.3 тэрбум төгрөг, Багануур 57.7 тэрбум төгрөг, Шивээ овоо 53.7 тэрбум төгрөгийн зах зээлийн үнэлгээтэй орж байна.




Хувьцааны арилжааны үнийн дүн

Энэ сард хувьцааны арилжааны үнийн дүн 2.0 тэрбум төгрөг бөгөөд өмнөх оны мөн үеэс 1.33 тэрбум төгрөг буюу 3 дахин өссөн байна. МХБ-ийн нийт арилжаанд хувьцаа 5 хувь, ЗГҮЦ-ны арилжаа 95 хувь эзэлж байна.




Нийт хийгдсэн хэлцлийн тоо

Энэ сард нийт 852 хэлцэл хийгдсэн бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад хэлцлийн тоо 70 буюу 9 хувиар өссөн байна.



Үнэт цаас нь арилжигдсан компанийн тоо

Энэ сард үнэт цаас нь арилжигдсан компанийн тоо 56 байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4 компаниар буурсан байна.




Нийт арилжаанд идэвхитэй арилжигдсан үнэт цаасны эзлэх хувь

Энэ сард нийт 70 компанийн хувьцаа арилжаалагдсанаас эхний ТОП 5-д УИД 1431.3 сая төгрөг, Би Ди Сек 299.9 сая төгрөг, УБ-БҮК 130.9 сая төгрөг, АПУ 38.4 сая төгрөг, Таван толгой 21.7 сая төгрөгийн хувьцаа арилжаалсан байна.



Засгийн газрын үнэт цаасны арилжаа


Энэ сард ЗГҮЦ-ны арилжаа 110.36 тэрбум төгрөгийн арилжаалагдсан бөгөөд үүнээс МХБ 33.2 хувийг, Монголбанк 66.8 хувийг нь арилжаалсан байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт арилжааны үнийн дүн 164.84 тэрбум төгрөг буюу 60 хувиар буурсан байна.



### АЛБАН ЖУРМЫН ДААТГАЛ

Жолоочийн албан журмын даатгал

Энэ сард жолоочийн албан журмын даатгалын хураамжийн орлого 1.7 төгрөг, нөхөн төлбөр 0.11 тэрбум төгрөг бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад хураамжийн орлого өөрчлөлтгүй, нөхөн төлбөр 89 хувь буурсан байна.




Зах зээлд эзлэх хувь

Энэ сард албан журмын даатгалын хураамжийн орлогоор 5 топ компанид Монгол даатгал 310.12 сая төгрөг, Бодь даатгал 288.3 сая төгрөг, Тэнгэр даатгал 258.5 сая төгрөг, Мандал даатгал 232.1 сая төгрөгийн, Миг даатгал 213.9 сая төгрөгийн орлоготой байна.

Тайлбар: 2015.10.30 өдрийн мэдээ болно.


Даатгалын компанийн зах зээлд эзлэх хувь



### БАРАА, ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ


Арилжааны үнийн дүн

Энэ сард ХААБ-ын арилжааны үнийн дүн 9.1 тэрбум төгрөг байсан бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 739.6 сая төгрөг буюу 8 хувь буурсан байна.



Биелсэн хэлцлийн тоо


Энэ сард ХААБ дээр биелсэн хэлцлийн тоо 83 байсан бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад хэлцлийн тоо 28 буюу 51 хувь өссөн байна.



Зах зээлд  
ээлэх хувь

Энэ сард ХАА-н биржийн арилжаанд нийт 4 брокерын компани оролцсон ба Хаантэлмэн 3.4 тэрбум төгрөг, Алтан шагай импекс 2.2 тэрбум төгрөг, Ханбүргэд хэнтий 1.3 тэрбум төгрөг, МЭТҮ 2.1 тэрбум төгрөгийн арилжаа хийсэн байна.

ХАА-н брокерын компаниудын зах зээлд эзлэх хувь




### ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САН

Зээлийн  
батлан  
даалт

Энэ сард зээлийн батлан даалт авах 1.03 тэрбум төгрөгийн 10 хүсэлт ирснээс 85.6 хувь буюу 0.883 тэрбум төгрөгийн 7 хүсэлтийг олгохоор шийдвэрлэсэн. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 45 хувь буурсан байна.

Тайлбар: Зөвхөн ЗБДС-аас олгохоор шийдвэрлэсэн батлан даалтын хэмжээ болно.

Зээлийн батлан даалтын хэмжээ /тэрбум төгрөг/




Эх сурвалж: СЗХ-ны зохицуулалтын байгууллагууд

### МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ДНБ

ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр 2015 оны эхний 3-н улиралд 11 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 286.4 тэрбум төг буюу 2.5 хувиар өслөө. Үүнд: ХАА салбар 12.8 хувь, аж үйлдвэр, үйлчилгээний салбар 6.2 хувиар тус тус өсөж удааширч байгаа нь аж үйлдвэр, уул уурхайн салбарын хөрөнгө оруулалт бага байгаатай холбоотой. ДНБ, оны үнээр 2015 оны эхний 9 сард 16834.1 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 665.1 тэрбум төг буюу 4.1 хувиар өссөн.

ДНБ-ий өсөлт, хувиар  
(үйлдвэрлэлийн арга, 2010 оны зэрэгцүүлэх үнээр, өмнөх оны мөн үеийнхээс)



Төсөв


Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн нийт хэмжээ 2015 оны эхний 10 сард 4.56 их наяд төгрөг, зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 5.48 их наяд төгрөг болж, улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 915.3 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа. Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал өмнөх оны мөн үеэс 636.8 тэрбум төгрөгөөр өсөхөд зарлагын өсөлт нь орлогын өсөлтөөс 12.7 пунктээр илүү байгаа нь нөлөөлжээ.

Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, зарлага, тэнцэл, жил бүрийн эхний 10 сарын байдлаар, тэрбум төг




Гадаад худалдаа

Нийт бараа эргэлтийн хэмжээ 2015 оны эхний 10 сард 146 оронтой худалдаа хийж, өмнөх оны мөн үеийнхээс 1988.7 сая ам.дол буюу 21.9 хувиар буурчээ. Үүнд: Экспортын хэмжээ өмнөх оны мөн үеийнхээс 14.7 хувиар буурахад эрдэс бүтээгдэхүүний экспорт 700.6 сая ам.дол, нэхмэл бүтээгдэхүүнийх 35.7 сая ам.дол-аар буурсан нь голлон нөлөөлсөн байна. Импортын хэмжээ өмнөх оны мөн үеийнхээс 29.3 хувиар буурахад эрдэс бүтээгдэхүүний импорт 451.4 сая ам.дол, авто, агаар, усан замын тээврийн эд ангийнх 233.3 сая ам.дол, машин тоног төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл тэдгээрийн эд ангийнх 217.0 сая ам.дол-аар буурсан нь голлон нөлөөлжээ.



Хэрэглээний үнийн индекс

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2015 оны 10 дугаар сард өмнөх сарынхаас 0.7 хувиар буурахад хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 3.3 хувиар буурсан нь голлон нөлөөлсөн байна. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2015 оны 10 дугаар сард оны эхнээс 1.9 хувиар өсөхөд 1.3 нэгж (70.9 хувь) нь боловсролын үйлчилгээний бүлгийн үнийн өсөлтөөс шалтгаалсан байна.



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, [www.1212.mn](http://www.1212.mn)

## МӨНГӨНИЙ ТОЙМ

Мөнгөний нийлүүлэлт



Мөнгөний нийлүүлэлт 2015 оны 10 дугаар сард 9900.3 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 0.3 хувь, өмнөх оны мөн үеэс 0.7 хувиар буурчээ. Тус 0.7 хувиар буурсны 3.7 нэгж хувийг гадаад валютын хадгаламж, 1.5 нэгж хувийг төгрөгийн хадгаламж, -0.2 нэгж хувийг хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө, -1.0 нэгж хувийг төгрөгийн харилцах, -4.8 нэгж хувийг гадаад валютын харилцах тус тус бүрдүүлсэн байна. Мөнгөний нийлүүлэлтийн 52.7 хувийг төгрөгийн хадгаламж, 20.8 хувийг валютын хадгаламж, 11.7 хувийг төгрөгийн харилцах, 10 хувийг валютын харилцах, 4.7 хувийг хадгаламжийн байгууллагуудаас гадуурх мөнгө эзэлж байна.

Зээл, зээлийн хүү



Хадгаламжийн байгууллагуудаас олгосон зээл өмнөх сарынхаас 0.2 хувь буюу 28.4 тэрбум төгрөг, өнгөрсөн оны мөн үеэс 7.2 хувь буюу 923.4 тэрбум төгрөгөөр буурч 11.9 их наяд төгрөгт хүрсэн байна. МИК ОССК-д шилжүүлсэн зээлийг оруулж тооцвол зээлийн үлдэгдэл 13.6 их наяд төгрөг байна.

Нийт зээлийн үлдэгдлийн 85.6 хувийг хэвийн зээл, 7.2 хувийг хугацаа хэтэрсэн зээл, 7.2 хувийг чанаргүй зээл тус тус эзлэв. Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь өнгөрсөн оны мөн үеийнхээс 2.5 нэгж хувиар өссөн байна.

Төв банкны үнэт цаасны жигнэсэн дундаж хүү 2015 оны 10 дугаар сард өнгөрсөн оны мөн үеэс 0.9 нэгж хувиар өсч жилийн 13.01 хувь болов. Банкуудын тухайн сард олгосон төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү өнгөрсөн оны мөн үеэс 1.1 нэгж хувиар өсч жилийн 203 хувь, гадаад валютынх өмнөх оны мөн үеэс 1.1 нэгж хувиар буурч жилийн 11.4 хувь болжээ. Харилцах, хадгаламжийн жигнэсэн дундаж хүү өөрчлөлт багатай байна.


Валютын ханш

Төгрөгийн ам.доллартай харьцах ханш 2015 оны 10 дугаар сарын эцэст 1991.67 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 129.3 төгрөгөөр суларсан байна. Тайлант сард төгрөгийн ам.доллартай харьцах дундаж ханш 1993.35 төгрөг байв.



Орон сууцны үнийн индекс

Тухайн 10 дугаар сарын байдлаар орон сууцны үнийн индекс өмнөх сараас 2.0%-аар, өнгөрсөн оны мөн үеэс 11.5%-аар тус тус буурчээ. Шинэ орон сууцны 1м.кв дундаж үнэ 2015 оны 10 дугаар сарын байдлаар 2,047,000 төгрөг болж өнгөрсөн оны мөн үеэс 3.6%-аар буурсан байна. Хуучин 2 өрөө байрны дундаж үнэ нь 2015 оны 10 дугаар сарын байдлаар 86,980,000 төгрөг болж өмнөх сараас 2.0 хувиар, өнгөрсөн оны мөн үеэс 12.0 хувиар тус тус буурсан байна.



Орон сууцны зээл



Тухайн сард олгосон ипотекийн зээл өмнөх сараас 2.7 хувиар өссөн ч өмнөх оны мөн үетэй харьцуулахад 28.2 хувиар буурсан байна.

Шинээр олгосон зээлийн 73.2 хувь буюу 58.8 тэрбум төгрөг нь ОСИСТТБХ-ийн зээл, 26.8 хувь буюу 21.5 тэрбум төгрөг нь банкуудын өөрийн эх үүсвэрээс олгосон зээл байна.

Олгосон зээлийн 55.8 хувь нь 16-20 жилийн хугацаатайгаар олгогдсон. Нийт ипотекийн зээлийн үлдэгдлийн 68.2 хувь нь 16-20 жил, 19.1 хувь нь 11-15 жил, 10.7 хувь нь 6-10 жил, 2.0 хувь нь 1-5 жилийн хугацаатай байна.

**Тайлбар:** ОСИСТТБХ -“Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр”

## ОЛОН УЛСЫН САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛ, ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

Эдийн засгийн өсөлт

Бодит ДНБ-ийн жилийн өсөлт тус графикт 2012 оноос хойш Хятад улс буурч байхад бусад нь өсөх хандлагатай байна.  
Хөгжиж байгаа орнуудын эдийн засгийн өсөлтөөс хөгжингүй орнуудын өсөлт илүү хурдтай байх хандлагатай байна.




Инфляц

Жилийн инфляц тус графикт 2012 оноос хойш дэлхийн хандлага буурч байхад Хятад, ОХУ-д өсөх хандлагатай байна.  
Хөгжиж байгаа орнуудын жилийн инфляцийн бууралтаас хөгжингүй орнуудын инфляц илүү хурдтай буурах хандлагатай байна.




Экспорт, импортын өсөлт

2015 онд дэлхийн цэвэр экспорт хасах гарах бол зүүн азийн цэвэр экспорт нэмэх гарах хандлагатай байна.  
Дэлхийн экспорт, импортын өсөлтөөс Зүүн азийн өсөлт илүү байх хандлагатай байна.




Валютын ханш

2015 оны 10 дугаар сарын тухайн улсын валютын ханшийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад евро 15 хувь, рубль 58 хувь, иен 12 хувь, юань 4 хувь, төгрөг 8 хувь өссөн байна.  
2015 оны 10 дугаар сарын тухайн улсын валютын ханшийг өмнөх сартай харьцуулахад юань 0.3 хувь төгрөг 0.1 хувь, рубль 3.6 хувь буурч, иен 0.4 хувь, евро 2.2 өссөн байна.



Металлын ханш

2015 оны 9 дүгээр сарыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1 трой унц /31.1 гр / алт 9 хувь, цагаан алт 29 хувь, мөнгө 20 хувь үнэ буурсан байна.  
2015 оны 9 дүгээр сарыг өмнөх сартай харьцуулахад 1 трой унц алт 0.6 хувь өсч, цагаан алт 2 хувь, мөнгө 1.3 хувь үнэ буурсан байна.



Түлшний ханш

2015 оны 9 дүгээр сарыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад сая тонн нүүрс Австралид 18 хувь, сая тонн байгалийн хий Америкт 32 хувь, Европт 27 хувь, Японд 41 хувь буурсан байна.



Эх сурвалж: Дэлхийн банк, ОУВС, НҮБ